



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/2021

Улаанбаатар хот

Нийслэлийн Түргэн тусламжийн  
төвийн данс бүртгэлээс тээврийн  
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, эзэмшигч байгууллагад нь сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 216,946,666 (хоёр зуун арван зургаан сая есөн зуун дөчин зургаан мянга зургаан зуун жаран зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Түргэн тусламжийн төв (С.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 1,500,000 (нэг сая таван зуу) төгрөгөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг Нийслэлийн Түргэн тусламжийн төв (С.Ариунболд)-д үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Нийслэлийн Түргэн тусламжийн төв (С.Ариунболд)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000821



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 09 дугаар сарын 14 -ны өдрийн А.Б.Б. дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/д	Байгууллагын нэр	Автомашинны марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Бүртгэлд тусгах үнэ	/төгрөгөөр/
1		Хьюндай старекс 27-34 УНД	37,950,000.0	37,950,000.0	0.0	300,000.0	
2		Хьюндай старекс 23-40 УНЕ	37,950,000.0	37,950,000.0	0.0	300,000.0	
3	Нийслэлийн Түргэн тусламжийн төв	Хьюндай старекс 05-94 УНТ	48,033,333.0	48,033,333.0	0.0	300,000.0	
4		Хьюндай старекс 05-14 УНТ	48,033,333.0	48,033,333.0	0.0	300,000.0	
5		Хьюндай старекс 27-99 УНС	44,980,000.0	44,980,000.0	0.0	300,000.0	
<b>Дүн</b>			<b>216,946,666.0</b>	<b>216,946,666.0</b>	<b>0.0</b>	<b>1,500,000.0</b>	